



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.10 дахь заалтыг тус тус1. үндэслэн ТУШААХ нь:

1.Эрчим хүчний “Салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ж.Хичээнгүй)-т даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 128 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600000081

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын  
31-ний өдрийн 01 дүгээр тушаалын хавсралт

## САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын эрчим хүчний салбарын дээд боловсролтой мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг, эрх олгох, түүнийг төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулж, хяналт тавихтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна. Мэргэжилтэн гэдэгт эрчим хүчний салбарын инженер, эдийн засагчид хамаарна.
- 1.2. Монгол Улсын эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, түвшин, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарт тавих шаардлага, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тооцох ажлыг сайжруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэлийг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино. Мэргэшлийн зэрэг нь цаашид мэргэжлээрээ аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх /лиценз, тусгай зөвшөөрөл/ олгох үндэслэл болно.
- 1.3. Мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах ажиллагааг удирдах, түүнд хяналт тавих ажлыг Эрчим хүчний яам, ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн хамтарсан "Салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох" орон тооны бүс Зөвлөл (Цаашид Зөвлөл гэнэ) эрхэлнэ.
- 1.4. Эрчим хүчний салбарын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд, иргэд тухайн зэрэглэлтэй мэргэжилтний ажлын үр дүн, алдаа дутагдлыг Зөвлөлд тухай бүр мэдээлж байна. Энэ нь мэргэжилтний зэргийг олгох, сунгах, цуцлах үндэслэл болно.
- 1.5. Инженерийн мэргэшлийн зэрэг нь мэргэшсэн ба зөвлөх, эдийн засагчийн зэрэг нь мэргэшсэн ба тэргүүлэх зэргийн төсөвчин гэсэн шатлалтай байна.
- 1.6. Мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох, сунгах ажиллагаатай холбогдсон Зөвлөлийн шийдвэрийг ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль хэрэгжүүлнэ.
- 1.7. Сургалтад хамрагдах шалгаруулалтад оролцсон болон зэрэг авсан мэргэжилтнүүдийн материал, мэдээлэл бусад холбогдох баримт бичгийг сургалт явуулж буй ШУТИС-ЭХС дээр хадгална.

### Хоёр. Зэрэг горилогчид тавих шаардлага

- 2.1. Мэргэшсэн инженерийн зэрэг горилогч нь дараах болзлыг хангасан байна.
  - 2.1.1. Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж эрчим хүчний чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэйгээр дээд боловсрол эзэмшсэн байна.



- 2.1.2. Мэргэшсэн зэрэг горилогч нь магистрын зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан байна.
- 2.1.3. Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жилийг нь үйлдвэрлэл дээр ажиллаж, 3-аас доошгүй бүтээлч ажил үйлдвэрлэлд нэвтрүүлж байгууллагын инженер техникийн ажилчдын зөвлөл, гүйцэтгэх захирал, ерөнхий инженерээр баталгаажуулсан байна.
- 2.1.4. Ажиллах хугацаандаа эрдэм шинжилгээ судалгаа, оюуны бүтээлд оролцож 3-аас багагүй бүтээл хэвлүүлсэн байна.
- 2.1.5. Ажиллах хугацаандаа мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалтад хамрагдаж 6-аас доошгүй багц цаг (кредит цаг) цуглуулсан байна.
- 2.2. Зөвлөх инженерийн зэрэг горилогч нь дараах болзлыг хангасан байна. Үүнд:
  - 2.2.1. Энэхүү журмын 2.1 заалтыг хангасан буюу Эрчим хүчний салбарын мэргэжлийн зэрэг олгох зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэгч ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн мэргэшсэн инженерийн сургалтыг дүүргэж батламж авсан мэргэшсэн инженер байна.
  - 2.2.2. Мэргэжлээрээ 12-аас доошгүй жил ажилласан, үүнээс мэргэшсэн инженерийн зэрэг аваад 2 удаа сунгасан байна.
  - 2.2.3. Мэргэшсэн инженерийн зэрэггүй боловч тухайн салбарын мэргэжлээр боловсролын докторын зэрэг хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 5-аас доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлсэн байна.
  - 2.2.4. Мэргэшсэн зэрэг авснаас хойш мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалтад хамрагдаж 6-аас доошгүй багц цаг (кредит цаг) цуглуулсан байна.
  - 2.2.5. Ажиллах хугацаандаа эрдэм шинжилгээ судалгаа, оюуны бүтээлд оролцож 6-аас багагүй бүтээл хэвлүүлсэн байна.
  - 2.2.6. Тухайн ажиллаж байгаа байгууллагаас зөвлөх инженерийн сургалтад хамрагдахыг дэмжсэн албан бичгийг үндэслэн бүртгэнэ.
- 2.3. Мэргэшсэн болон тэргүүлэх төсөвчний зэрэг горилогч нь дараах болзлыг хангасан байна. Үүнд:
  - 2.3.1. Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж эрчим хүчний болон эдийн засгийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэйгээр дээд боловсрол эзэмшсэн байна.
  - 2.3.2. Төсөвчний тэргүүлэх зэрэг горилогч нь мэргэшсэн зэрэг авснаас хойш 3-аас доошгүй жил төсвийн ажил эрхэлсэн байна.
- 2.4. Бусад шаардлагад дараах шаардлага хамаарна. Үүнд:

- 2.4.1. Бүтээл нь мэргэжил дээшлүүлэх талаар зөвлөлөөс баталсан журамд заасан шаардлагыг хангасан байна.
- 2.4.2. Зөвлөл горилогчийн бүтээлийг хянан магадлах явцад бүтээлээ худал мэдүүлэх, эсвэл бусдын бүтээлийг буруу баталгаажуулсан байдал илэрвэл буруутай этгээдэд зэрэг олгохоос түдгэлзэх, урьд авсан зэргийг нь бууруулах эсвэл хүчингүй болгоно.
- 2.4.3. Мэргэжлийн болон ёс зүйн зохих шаардлагыг хангасан байна.
- 2.4.4. Горилогч нь тухайн мэргэшсэн чиглэлээрээ салбарын холбогдолтой нэгээс доошгүй улсын стандарт, бусад норм, нормативын баримт бичгийг заавал боловсруулсан байна.
- 2.4.5. Зэрэг горилогч нь Зөвлөлөөс зэрэг олгох үйл ажиллагаатай холбогдуулан тогтоосон төлбөрийг төлсөн байна.

### **Гурав . Зэрэг горилох хүсэлт гаргах**

- 3.1. Зэрэг горилогч нь дараах баримт, бичгүүдийг бүрдүүлж зарласан хугацаанд багтаан Зөвлөлийн цахим хуудсанд мэдүүлсэн байна. Үүнд:
  - 3.1.1. [www.surgalt.pes.edu.mn](http://www.surgalt.pes.edu.mn) цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулсан байх;
  - 3.1.2. Ажил байдлын тодорхойлолт;
  - 3.1.3. Иргэний үнэмлэхийн хуулбар
  - 3.1.4. Нийгмийн даатгалын магадлагаа (и-монголиа)
  - 3.1.5. Дипломын хуулбар;
  - 3.1.6. Мэргэжил дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээ, бусад баримтууд;
  - 3.1.7. Бүтээлийн тайлан, жагсаалт (загварын дагуу гаргаж, баталгаажуулсан);
  - 3.1.8. Шалгаруулалтын төлбөрийн баримт.
- 3.2. Зэрэг горилогч нь ажил байдлын тодорхойлолтыг ажиллаж буй байгууллагаасаа авсан байна. Шаардлагатай бол холбогдох бусад байгууллага тодорхойлолт гаргаж болно.
- 3.3. Бүтээлийн тайланг ажиллаж буй байгууллага болон зөвлөх зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтэн хянаж баталгаажуулсан байна. Тайланд бүтээлийн фото зураг, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар зэргийг хавсаргана.
- 3.4. Горилогч нь онцгой бүтээл гаргасан тохиолдолд горилогчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн энэ журмын 2.1, 2.2-д заасан хугацааг Зөвлөл хэлэлцэж багасгаж болно.
- 3.5. Дараах тохиолдлуудад зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн Зөвлөл хэлэлцэж мэргэжлийн шалгалтаас чөлөөлж болно. Үүнд:
  - 3.5.1. Онцгой бүтээл гаргасан (эрчим хүчний салбарт хэрэгжсэн улсын чанартай төсөл, хөтөлбөр, ном, хууль эрх зүйн акт, норм, норматив удирдан боловсруулсан);
  - 3.5.2. Мэргэжлийн чиглэлээр боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.



## **Дөрөв. Зэрэг олгох шалгаруулалтын ажиллагаа**

- 4.1. Зөвлөл нь шалгаруулалтыг мэргэжилтнүүдийн мэдлэгийн түвшин, мэргэшлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл, туршлагыг тодорхойлолт, бүтээлийн тайланг зохих журмын дагуу магадлан шалгах замаар тодорхойлно.
- 4.2. Шалгалт нь мэргэшсэн зэрэг горилогчид нэг, зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилогчид хоёр үе шаттайгаар явагдана. Үүнд:
  - 4.2.1. Нэгдүгээр шат. Мэргэжлийн шалгалт (Шалгалтын комисс тусгайлан боловсруулж хэвлүүлсэн номноос шалгалтын өдөр танхимд 50 асуултыг сонгоно.)
  - 4.2.2. Хоёрдугаар шат. Төгсөлтийн ажлын хамгаалалт. Төгсөлтийн ажлын хамгаалалтанд техник технологийн шийдэл, зураг, төсөл, судалгааны ажлын тайлан, төсөвт экспертиз хийх ажлууд орж болно.
- 4.3. Зэрэг горилогч нь мэргэжлийн шалгалтад авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийг авбал тэнцсэнд тооцно.
- 4.4. Зөвлөх инженерийн гүйцэтгэх судалгааны ажлын сэдвийг сургалт эхлэхээс 2-оос доошгүй сарын өмнө зөвлөлөөр хэлэлцэн баталж зарласан байна. Зөвлөх инженерийн зэрэг горилогч нь зөвхөн батлагдсан сэдвээс сонгож судалгааны ажлыг гүйцэтгэх ба нэг сэдвийг 2-оос дээш горилогч сонгохгүй.
- 4.5. Шалгаруулалтын хоёрдугаар шатанд орж буй зөвлөх зэрэг горилогч нь Зөвлөлөөс зөвшөөрсөн сэдвээр, батлагдсан зааврын дагуу төгсөлтийн ажил бичиж, тэргүүлэх зэрэг горилогч төсөвчин нь комиссоос сонгосон төсөвт экспертиз хийж дүгнэлт гаргах замаар төгсөлтийн ажил гүйцэтгэх ба зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй тус бүр 2 мэргэжилтэн буюу эрдэмтдээс шүүмж, санал авч мэргэжлийн шалгалтын комисст хамгаална. Энэ шатанд комисс нь горилогчийн бүтээл, туршлагыг мөн үнэлж нэгтгэн, 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.
- 4.6. Мэргэжлийн шалгалт, төгсөлтийн ажлын хамгаалалтыг Зөвлөлөөс томилсон комисс авна. Шалгалтын комисс болон зэрэг горилогч нь батлагдсан шалгалтын журмыг баримтална.
- 4.7. Шалгалтын комисс нь горилогчийн шалгалтын дүн, бүтээл, туршлагад үндэслэн зэрэг олгох саналаа Зөвлөлд оруулна.

### **Тав. Зэргийг сунгах, цуцлах**

- 5.1 Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн 3 жил тутамд сунгуулах ба 2 удаа сунгуулаад 3 дахь удаагаа хугацаагүй болно, зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн 5 жил тутам 1 удаа зэргээ сунгаж баталгаажуулна.
- 5.2 Зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтний зэргийг хоёр удаа сунгах ба гурав дахь сунгалтаас гэрчилгээнд хугацаа заахгүй. Зэргээ сунгуулах хүсэлтийг (өргөдөл) энэ хугацаанд хийсэн ажлын болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тухайн албан байгууллагын ерөнхий инженерийн зэрэг сунгахыг зөвшөөрсөн тодорхойлолтын хамт зөвлөлд



бичгээр ирүүлнэ.

- 5.3 Зэргээ сунгуулах тохиолдолд тайлан хамгаалалт, шалгаруулалтад 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлбэл зэргийг сунгах саналыг комисс Зөвлөлд оруулж шийдвэрлүүлнэ.
- 5.4 Дараах тохиолдлуудад Зөвлөл хэлэлцэж зэргийг бууруулах, эсвэл цуцлах шийдвэр гаргаж болно. Үүнд:
  - 5.4.1. Зэргээ бууруулах, эсвэл цуцлуулах хүсэлтийг өөрөө гаргасан;
  - 5.4.2. Тухайн албан байгууллагын ерөнхий инженерээс зэргийг бууруулах, цуцлах санал ирүүлсэн;
  - 5.4.3. Тайлант хугацаанд мэргэшсэн чиглэлээрээ ажил үйлчилгээ явуулаагүй;
  - 5.4.4. Шалгаруулалтанд хугацаандаа болон хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй;
  - 5.4.5. Шалгаруулалтанд тэнцээгүй;
  - 5.4.6. Ёс зүйн доголдол гаргасан;
  - 5.4.7. Мэргэжлийн алдаа дутагдал гаргасныг эрх бүхий байгууллага тогтоосон;
  - 5.4.8. Гэмт хэрэгт шийтгүүлсэн.

### **Зургаа. Зэрэгтэй мэргэжилтний эрх**

- 6.1. Зэрэгтэй мэргэжилтэн нь Зөвлөлөөс баталсан загвар бүхий гэрчилгээтэй, зөвлөх зэрэгтэй бол хувийн тэмдэгтэй байна. Гэрчилгээ, тэмдэгт эзэмшигчийн нэр, бүртгэлийн дугаар, зэргийн хүчинтэй байх хугацааг заана. Гэрчилгээнд тухайн зэргийн хүрээнд хамаарах ажил үйлчилгээг зааж өгнө. Тэмдгийн эх загварын дардасны нэг хувийг зөвлөл болон хяналтын байгууллагад хадгалуулсан байна.
- 6.2. Зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянаж зөвлөсөн ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичиг, зураг төсөл, экспертиз зэрэгт гарын үсэг зурж хувийн тэмдгээ дарна.
- 6.3. Мэргэшлийн зэрэг авсан мэргэжилтнүүд нь нэгдэж аж ахуйн нэгжийн аль нэг хэлбэрээр зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ бүрэлдэхүүндээ нэгээс доошгүй зөвлөх болон тэргүүлэх мэргэжилтэнтэй байна. Тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь төсөв зохиохын зэрэгцээ бусдын зохиосон төсвийг шалгаж баталгаажуулах, экспертиз хийх эрх эдэлнэ. Мэргэшсэн мэргэжилтэн нь бие даан экспертиз хийхгүй боловч тэргүүлэх мэргэжилтний удирдлага дор уг ажилд оролцож болно.
- 6.4. Зэрэг олгох болон зэргээ сунгуулах шалгаруулалтад хүндэтгэх шалтгааны улмаас орж чадаагүй бол уг шалтгааныг нотолсон баримт бичгийг бүрдүүлж Зөвлөлд өгч шийдвэрлүүлнэ.
- 6.5. Шалгуулагч нь шалгаруулалтын талаарх гомдол, саналаа Зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.6. Шалгуулагч нь шалгалтад тэнцээгүй бол нэг жилээс доошгүй хугацааны дараа шалгалтыг дахин өгөх хүсэлтийг зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ.

## **Долоо. Зэрэгтэй мэргэжилтний үүрэг, хариуцлага**

- 7.1. Зэрэгтэй мэргэжилтэн нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, журам, зааврын дагуу техник технологийн зохих түвшинд, хариуцлагатай, чанартай, ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэнэ.
- 7.2. Зэрэгтэй мэргэжилтнүүд нь өөрийн бие дааж болон удирдан хийлгэсэн, зөвлөж, хянаж баталгаажуулсан ажлын үр дүн, чанарыг бүрэн хариуцах ба өөрийн буруугаас учирсан хохирол, хариуцлагыг холбогдох хуулийн дагуу хүлээнэ.
- 7.3. Зэргээ цуцлуулсан мэргэжилтэн Зөвлөлд хувийн тэмдэг, гэрчилгээгээ хураалгана.

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**